

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

ЖУРМЫН ХАВСРАЛТ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай А/41 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дүрмийн 4.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-ын нэгдүгээр хавсралт, журмын 3.16 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв /Д.Нарансүх/-д даалгасугай.

САЙД